

БАЯНЦАГААН ДАХЬ ХИЛИЙН 23 ДУГААР ОТРЯД

Хилийн отряд. Отрядын штаб нь хилийн албаны, байлдааны бэлтгэлийн, холбооны, тоо бүртгэлийн, тагнуулын гэсэн таван тасагтай. Улс төрийн анги нь комиссар, нам эвлэлийн товчоо, ухуулах ажлын зааварлагчид, аж ахуй /арын алба/, эд ба хүнс групп, хүн малын эмнэлэг, ажил команд зэрэг нэгжтэй, хилийн суман хоёр, бэлтгэл суман нэг, сургуулийн ба хүнд пулемётын салаа, хилийн 9 заставтай байлаа. Хилийн суман тус бүр хүн, малын бага эмч, тусгай ангийн төлөөлөгчтэй. Заставууд нь намын үүр, залуучуудын эвлэлийн анхан шатны үүртэй байсан. Хилийн отряд нь хилийн шугамнаас дотогш 30 км, суман заставууд нь 10-15 км орчимд байрлаж байжээ.

Хилээ хамгаалсан нь. Тус отряд нь Монгол Улсын зүүн хязгаар Соёлз уул /Тэмээнэ/-аас Сүүл сэргэн гэдэг ухаа хүртэл /Халхын цагаан уулнаас урагш 10 орчим км/ 400-аад км хэсгийг хариуцан нэг заставт дунджаар 40 км хилийн зурвас оногдож байв.

Хилийн заставын хилчин бүр өдөр шөнийн 24 цагт хилийн манааны үүргийг 8 цаг гүйцэтгэх хатуу хуваарьтай байсны дээр заставын харьяалсан хилийн шугам дээр тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй манааг байнга ажиллуулж байжээ. Зөрчил гарч болзошгүй зарим газарт хөнгөн пулемёт бүхий хүч нэмэгдүүлсэн байнгын постыг 7 хоногийн хугацаатай тавьж байв. Түүнчлэн баяр ёслолын үеэр заставуудад төвийн бэлтгэл сумангаас хүч нэмэгдүүлэн хилийн манааны тоог олшруулах, зарим онцлог газарт тасаг хүртэл хүчээр хүч нэмэгдүүлж байжээ. Тус отряд нь баруун талдаа 20-р отряд; зүүн талдаа 24-р отрядтай хил залгадаг ба гадаад талаараа өвөрмонголын солон, үзэмчин хошуудтай хил залгадаг байв. Отрядын харьяалсан хилтэй гадаад талаараа хил залгаж байсан Хандгайт, Халуун рашаан, бага Хянганы нуруу зэрэг газруудад Японы түрэмгийлэгчид дайны зориулалттай цэргийн бэхлэлт зам гүүр холбоо харилцаа, цэргийн байр, зэвсэг техникийн агуулах, галын цэгүүд, нуувч, блиндаж зэрэг байгууламжийг барьж бэлтгэж байлаа. Мөн Хандгайт, Халуун рашаан, Хар ямаат зэрэг газруудад Японы моторжуулсан ба явган цэргийн томоохон нэгтгэл ангиудыг байрлуулан дайн байлдааны бэлтгэлээ хангаж бэлэн байдалд байжээ. Хилийн шугамнаас цааш 70-80 км орчим зайд байдаг Солонд цэргийн нисэх онгоцны цементэлсэн аэродром байгуулж Хандгайт, Халуун рашаан, Вангийн сүм болон Японд эзлэгдсэн Хятадын төв хотуудтай өргөн төмөр замаар холбогдсон байв. Вангийн сүмд Японы тагнуулын төв байрлаж байсан

ба түүний салбарууд Халуун рашаан, солон, Зүүн үзэмчин хошуудад байрлаж байсан. Хилийн суман заставууд нь дор дурдсан байршилтай байсан. Үүнд:

- 1-р суман Авдрантад /сумангийн дарга Баньд/
- 2-р суман Нарийн гол /Дэгээ/ /сумангийн дарга Ванданхүү/
- 1-р застав Аглууд /заставын дарга Самбуу/
- 2-р застав Жирмийн ухаад /заставын дарга Гэлэгдандар/
- 3-р застав Авдрантад /дарга Дагва/
- 4-р застав Ламын хайрханд /дарга Шагдар/
- 5-р застав Задгайд /хар морьт/ дарга Рагчаа/
- 6-р застав Хайрхан толгойд /дарга Даржаарагчаа/
- 7-р застав Хар ямаат /дарга Дашхүү/
- 8-р застав Нарийн гол /дэгээ/ дарга Ванданхүү/
- 9-р застав Нөмрөгт /дарга Нанзаа /эдгээр 2 суман, 9 заставтай

байсан бөгөөд сүүлд шинээр нэг застав нэмэгдэж Их айлын худаг гэдэг газар байрлуулан /дарга Доржготов/ 10 заставтай болжээ.

Чөлөөлөх дайнд оролцсон нь 1945 оны 8 дугаар сард ЗХУ Японд зарлаж улаан армийн ангиуд Монгол Улсын хилийг анх нэвтрэн гарахад отрядын штабын дарга Доржготов, холбооны дарга Чимэддорж, хэлмэрч Мөнхөөв, 5 дугаар тасгийн дарга Даваасүрэн нар улаан армийн 53 дугаар корпусын штабтай хамт хил нэвтрэн гарч Япон Манжийн цэргийн байршил, зам харилцаа, цэргийн бэхлэлт, газар орны байдал, ус худаг, ард түмний зан заншил зэргийг судалж мэдэхэд нь туслах зорилгоор үүрэг гүйцэтгэж Вангийн сүм, Тонлио хот хүртэл явж байлдааны үүрэг гүйцэтгээд Японы цэрэг үг дуугүй бууж өгч байлдаан нэгэнт зогссон учир эх орондоо буцаж ирсэн билээ.

Отрядын дарга Баатарсүрэн, сургагч Устинов нарын командалсан баг цэрэг тус улсын зүүн хязгаар Соёлз уулын чиглэлээр хил нэвтрэч учагогын станц дээр түр байрласан ба мөн хязгаарын газрын байлдааны хэлтсийн ажилтан Шагдараар удирдуулсан 2 дахь баг цэрэг Нуухын сүмийн чиглэлээр Зүүн үзэмчин хошууны Гахил сүмд түр байрлан нутгийн ард түмний аюулгүй байдал, эд хогшил, мал хөрөнгийг хулгай дээрмээс хамгаалах, орон нутгийн засаг захиргааг сэргээн босгоход туслах, Японы цэргийн үлдэгдлийг мөрдөн мөшгиж илрүүлэн баривчлах, устгах, ялангуяа япон тагнуулын байгууллага болон япончуудад идэвхитэй тусалсан урвагч Зүүн үзэмчин хошууны туслагч Довдон, гүн Батсүх захирагч зэрэг олон арван этгээдийг илрүүлж баривчлан арга хэмжээ авсан болно. Цагийн байдал нэгэнт тайвширсан тул Өвөрмонголын нутагт байсан 2 баг

цэргийг буцаан татсан ба харин Солон хошууны нутагт 40 хүнтэй нэг группыг мөн оны 10 дугаар сарын 10 хүртэл Вангийн сүм, Хар ямаат, Дэвсэгийн зэрэг газар маршрутаар явуулан ажиллуулж байлаа. Энэ группыг Хязгаарын газрын тагнуулын хэлтсийн ажилтан Гүрсэд отрядын 5 дугаар тасгийн дарга Даваасүрэн нар удирдан явж байжээ.

Зүүн үзэмчин хошууны ноён Дорж ван, ард Амгалан, мөн хошууны хэсэг хүмүүс хамтран Монгол Улсын харьяалалд дагаар орохоор санал нэгдэн хүсэлт гаргасны хүлээн авч Монгол Улсын Засгийн газар уламжлан улмаар хариу зөвшөөрөл авсны үндсэн дээр 1945 оны 12 дугаар сард Авдрантын заставын чиглэлээр 100 орчим өрх айл, 10000 гаруй толгой мал, 400 орчим хүн амтай нүүдэллэн орж ирснийг хүлээн авч отрядын штабаас комисс томилон хүн ам, мал хөрөнгийг бүртгэн улмаар Дорнод аймгийн гүйцэтгэх захиргаанд мэдэгдэн хилийн шугамаас дотогш 40 км-т орших Сөрийн манханд түр суурьшуулсны дараа Дорнод аймгийн гүйцэтгэх захиргаанаас төлөөлөгч томилон ирүүлж ардын хурал зохион байгуулж хуралдагсдын саналыг үндэслэн Хэрлэнбаян нэртэй сум байгуулан сумын даргаар ард Амгалан, нарийн бичгээр Дорж ван нарыг сонгож байжээ.

Өвөрмонголын Зүүн үзэмчин хошуунаас нүүдэллэн ирсэн айл өрхүүд хилийн шугамд ойролцоо нутаглах нь хилийн хамгаалалтад зарим талаар хүндрэл учруулж элдэв зөрчил будлиан үүсгэх зэргээр муу нөлөө үзүүлж байсан. Жишээ нь Дорж ноёны сүрэгчин байсан Цэрэн гэгч оргосныг Зүүн үзэмчин хошууны нутагт айлд байхад нь отрядын 5 дугаар тасгийн туслах Дэмбэрэл 2 хүний хамт баримвчлахаар очих үед тэрээр өөрийнхөө амийг хорложээ.

Энэ мэтийн шалтгаанаас Хэрлэнбаян сумыг нутгийн гүн рүү татаж Баянтүмэн хотоос хойш шилжүүлсэн юм.

Хилийн зөрчлийг шийдвэрлэсэн нь.

1.1941 онд Нөмрөгийн заставын чиглэл Соёлз уулын орчмоор зэвсэг бүхий 4 этгээд ан хийж яваа байдлаар хил нэвтрэн ирснийг мөн заставын хилийн манаа Аюуш ахлагчтай 3 хилчин илрүүлжээ. Тэр үед хилийн хэлэлцээр хийж байсан учир хилийн шугам дээр буу дуугаргах, зэвсэг хэрэглэхийг Дотоод Яамны сайдын тушаалаар хатуу хориглосон байсан тул ахлагч Аюуш овсгоо самбаа гаргаж "Та нар үнэхээр ан агнаж яваа юм бол ахлагчаа нааш нь ирүүлж бидэнтэй учир шалтгаанаа ярилцан тохирч болно. Та бид ах дүү монгол туургатан учир бие биедээ хар буруу санах хэрэггүй, нүүр нүүрээрээ уулзаж учир байдлаа ярилцаад хоёр тийш болох нь дээр, хэрэв

тэгэхгүй бол бид зэвсэг хэрэглэхээс аргагүй болно" хэмээн эелдэг зөөлнөөр учирлан хашгирч хэлэхэд айсан юмуу, итгэсэн юмуу ахлагчаар явсан нэгэн цахар манай хилчид дээр ирсэн байна. Түүнийг хилчид найрсаг байдлаар хүлээн авч манай дарга энд ойрхон байгаа ч түүнтэй уулзаж учир байдлаа хэлээд буц хэмээн дагуулж явсаар заставтаа авчирсан байна. Түүний мэдүүлгээс үзвэл манай хилийн хамгаалалт манааны байршил маршрутыг тагнан мэдэхээр японы тагнуулын байгууллагаас даалгавар авч ан хийж яваа нэрийдлээр тагнуул хийж яваагаа хүлээжээ. Ахлах манаа Аюуш туслахуудын хамт байлдааны хүндэт медалиар шагнагдсан билээ.

2.1943 онд Халх голын отрядын харьяалсан хилээр винтов, гар буу, дуран, гэрэл зургийн аппарат зэрэг зэвсэг хэрэгсэл, хоол хүнсээр бүрэн хангагдсан 6 тооны тагнуул япон үндэстэн Бонхроо гэгчийн удирдлагаар хил нэвтрэн ирж Халх голын отрядын байршлын гэрэл зургийг авч улмаар утсан харилцааны модыг даган явсаар Баянцагааны отрядын төвөөс урагш 2 км орчимд орших Элсэн манханы хонхорт /Малины хонхор/ нуугдан хоргодож байсныг Хязгаарын газрын прокурорын байцаагч Гэндэн хилийн ангиудаар ажиллаад отрядын төв рүү буцах замдаа морь хөтлөгч нэгэн хилчний хамт тэднийг илрүүлэн баривчилсан юм. Тагнуулын ахлагч мэдүүлэг өгөхдөө "Бид Вангийн сүм дэх поны тагнуулын газрын даалгавраар хилийн ангиудын хүн хүч, зэвсэг техник, хил хамгаалалт, зам харилцаа, газар нутгийн байдлыг судалж гэрэл зураг авах, бололцоо гарвал амьд хэл олзлох зорилготой яваа. Бид өмнө нь танай нутаг руу хэд хэдэн удаа тагнуулаар орж ирсэн бөгөөд энэ удаа үүргээ гүйцэтгэж чадах юм бол Японы төрийн дээд шагнал Алтан элээ гэдэг одонгоор шагнагдах байсан юм" хэмээн мэдүүлж байлаа.

3.Эд нар 23-р отряд ба Тамсагийн 6-р дивизээс хүч нэмэгдүүлэн Баянцагааны отрядтай зэргэлдээ байсан 1-р морин хорооны байршил орон сууц, цэргийн байр, агуулах контор, дарга нарын гэрүүд, агтны жүчээ, аргал түлш, нуувч, утасны шон зэргийн зургийг татсан ба бүдүүвч гар зураг хийж давхар баталсан байлаа. Хэрэв амьд хэл олзолвол хөл гарыг нь хүлж баглах нарийн олс хүртэл бэлтгэсэн байжээ. Хүн бүр хоол хүнс, унд усаа хавчиг үүргэнд хийж авч явжээ. Эдгээр 6 тагнуулчдыг барихад 4 хүн оролцсон ба тэд цөм төрийн дээд шагнал одон медалиар шагнагдсан гэж зарим ном хэвлэлд нийтлэгдсэн нь үнэнд нийцэхгүй ташаа байв. Энэ үед миний бие 23-р отрядын 5-р тасгийн даргаар ажиллаж байсан тул байцаагч Гэндэнгээс ирүүлсэн мэдээг хүлээн аваад отрядаас туслахаар очсон хүмүүсийн дотор биеэрээ байсны хувьд сайн мэдэх юм. Харин

байцаагч Гэндэнг төрийн дээд шагнал Алтангадас одонгоор шагнасан нь үнэн болно.

4.1944 онд хилийн 2 –р сумангаас түлшний мод бэлтгэн тээвэрлэж байсан 3 хилчин Нарийн гол /Дэгээ гол/-ын эхэнд хоноглож байхдаа харуул манаа гаргалгүй цөм унтаж амарсан учир зэвсэг бүхий хил зөрчигчид өглөө үүрээр гэнэт довтолжээ. Манай хилчид тохой хэрийн хэмжээтэй газар ухаж 2-3 шургаагаар өндөрлөсөн нуувчинд унтаж байсан хэдий ч 2 хилчин газар дээрээ нам буудуулан 1 нь нуувчныхаа үүдээр мөлхөн гарч буудалцахад хөх хувцастай 4-5 хүн мод таширлан хилийн зүг зугтаж явахыг харжээ. Энэ 3 хилчин бол тэр жил халагдах хуучин хашир хүмүүс байсан боловч хэт тайвшран догирхож сэрэмжгүй байснаас болж ийнхүү золгүй явдалд хүрсэн байна.

5.1944 онд 6-р заставын хилийн пост суудаг Нэргүй толгойн чиглэлээр японы харуул байсан Нуухын сүм гэдэг газраас 6-7 морьтой зэвсэг бүхий этгээд хил зөрчин манай постыг бүслэх зорилготой Нэргүй толгойн баруун талаар тойрч ирэхэд нь манай хилчид гал нээж нэг этгээдийг морьтой нь давхар буудаж устгасан байна. Тэр этгээдийн биед явсан бичиг баримтыг үзэхэд Нуухын сүм дэх хилийн харуулын дарга бөгөөд жинхэнэ япон үндэстэн байсан. Үүнээс үзэхэд японд эзлэгдсэн Манжуур, Өвөрмонголын хилийн харуулыг жинхэнэ япон дарга нар удирдаж байсан нь тодорхой байна.

6.1944 оны өвөл 6-р заставын харьяалсан хилээр Зүүн үзэмчин хошууны Чулуун гэгч нэвтрэн ирж хилийн манаанд баригдаад ямар зорилготой хил зөрчсөнөө мэдүүлэхдээ "Үүний өмнө танай хил дээр алагдсан япон хүний амь нэхэгдэж байгаа учир түүний алагдсан шалтгаан ба юу хийж явсан, чухам ямар байдалтай үхсэн, оршуулсан газар зэргийг үзэж мэдэх, энэ талаар танай хилийн цэргээс тодорхойлолт, баталгаа авахаар даалгавар авч томилолтоор яваа" хэмээсэн хошуу тамгын газраас тамгатай бичигтэй ирсэн байв. Энэ этгээдийг зохих баримт материалын хамт Хязгаарын Цэргийн газар хүргүүлсэн бөгөөд 1945 оны эхээр Чулууныг анх ирсэн газраар нь хил давуулан буцааж явуулсан. Чулууныг нутагтаа буцаж очмогц японы тагнуулын байгууллагаас шууд баривчлан шоронд хорьж хатуу ширүүн мөрдлөг явуулан тарчилган зовоож байтал 1945 оны чөлөөлөх дайн болж 23-р отрядаас Зүүн үзэмчин хошууны чиглэлээр үүрэг гүйцэтгэж явсан цэргийн анги тааралдаж сулласан байна. Үүнээс үзэхэд хил зөрчигч Чулуун нь өөр ямар нэг тагнуул туршуулын даалгавартай хил зөрчөөгүй болох нь тодорхой юм.

7.Тамсагбулагт байрлаж байсан ЗХУ-ын улаан армийн нэгтгэл

ангиас зэвсэг бүхий хоёр цэрэг эх орноосоо урван японд очиж амьдрахаар тус отрядын 1-р заставын участкаар хил нэвтрэхээр явж байсныг гүйцэтгэх ажлын шугамаар тусгай үүрэг гүйцэтгэж явсан ахмад Даваа сүрэн, морь баригч Дамдин нар илрүүлэн улмаар 1-р заставт холбоо барьж, урвагч 2 цэргийг баривчлахаар мөрдөн хөөж газар орныг самнан шалгаж явтал өндөр өвстэй гүн жалганд нуугдаж байгаад манай хилчидтэй гэнэт тулгарч ашигтай газар эзэлсэн ба зэвсэг хэрэглэхэд бэлэн байсан давуу талаа ашиглан гал нээж заставын улс төрийн орлогч Шагдарыг галт сумаар буудаж шархдуулсан. Түүнийг Тамсагбулагийн эмнэлэгт хүргэсэн боловч тусламж авч чадалгүй нас баржээ. Манай хилчид урвагчдыг амьд барихыг чухалчлан зэвсэг хэрэглээгүй учир цаг алдаж, тэдэнд боломж олгосон юм. Гэтэл нар шингэж харанхуй болох ойртох үед тэдэн рүү гал нээж нэг урвагчийг хүнд шархтуулан, нөгөөг нь хоёр хоногийн дараа амьд баривчилсан бөгөөд харин шархтай урвагч цэрэг хил дөнгөж нэвтэрч гараад үхсэн байлаа.

8.1943 онд 1-р заставын харьяалсан хилээр гадаадаас нэг этгээд хил зөрчин ирсэн нь Зүүн үзэмчин хошууны Ламын сүмд шавилан суудаг Самдан /Сандаг/ гэгч лам байлаа. Тэр мэдүүлэхдээ: "Гахил сүмд байдаг японы тагнуулын байгууллагаас Монгол улсад суурин суух, тагнуулын үүрэг гүйцэтгэх даалгавар авч ирсэн. Харин хил нэвтрэн ирсэн тухайгаа Өвөрмонголд амьдрал хүнд болсон тул Монголд амьдрах, гандан хийдэд шавилан суухаар яваа гэж мэдүүлэг өгөх даалгавартай" хэмээн мэдүүлэг өгсөн байна.

9.1943 оны хавар 1-р заставын харьяа Халхын цагаан уулнаас урагш 10 гаруй км-т орших Сүүл сэрвэн гэдэг газраар гадаадаас зэвсэг бүхий 30 орчим хүн ачааны машинтай хил зөрчин иржээ. Тэр үед тэнд хилийн манааны үүрэг гүйцэтгэж байсан Даваажав ахлагчтай гурван хилчин нэгийгээ заставтай холбоо бариулахаар явуулж хоёр хилчин нь газар орны байдлыг ашиглан нууц далд газраар явж хил зөрчигчдийн ар талд гарч хилийн талыг боон улмаар дайсны араас сэм дагаж хэсэг манханы дотор гэнэт тулгарсан байна. Хил зөрчигч нар манай хилчид руу гал нээсэн ба манай хоёр хилчин манханы хонхорт морио хэвтүүлж өөрсдөө биеэ далдлан хориглолтын байдалд орж тэнцвэргүй тулалдаанд оржээ. Гэтэл дайсан этгээд хүч давуугаа ашиглан манай хоёр хилчнийг бүслэн авч устгахаар шийдэж давшилтаа хумисаар ойртон ирж манай нэг хилчнийг нам буудсан байна. Ахлах хилчин Даваажав байрлалаа өөрчлөн бүслэлтээс гарч дайсан этгээдийн хил талыг боож буудалцаар байсан төдийгүй хэд хэдэн хүнийг устгаж шархтуулсан учир хил зөрчигчид шууд машиндаа сууж

замаа өөрчлөн зугтахдаа алагдсан хүмүүс ба шархдагсдаа аваад хилийн зүг зугтжээ. Ахлагч Даваажав ганцаараа тул арга буюу манааныйхаа үүргийг гүйцэтгэсээр үлдсэн байна. Заставын төв нь 30 гаруй км хол байсан учир ирэх очихын 60 гаруй км газар богино хугацаанд туслах хүчин ирж тусламж үзүүлэх үнэхээр бололцоогүй байсан байна. Ийнхүү тулгаралт болсон газар байдлыг очиж магадлан үзэхэд хил зөрчигчдөөс 10 орчим хүн шархдсан алагдсан байж болох ор мөр тодорхой илэрсэн байна. Хилчин Даваажавын байгуулсан гавьяа бол ганц дайчин ганцаардахгүй гэсэн цэрэг эрийн баатарлаг зориг, эх орныхоо төлөө халуун амь бүлээн цусаа хайрлахгүй тэмцэнэ гэж Монгол улсынхаа сүлд тугийн өмнө өргөсөн ариун тангарагаа нэр төртэй биелүүлж чадсаны бодит баталгаа мөн тул манай Хилийн Цэргийн түүхэнд үүрд дурсагдах ёстой. Түүний гавьяа зүтгэлийг өндрөөр үнэлж төрийн дээд шагнал Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор шагнасан юм.

Ар тал, хангалт. Отрядын арын алба нь хилийн ба төвийн анги салбарын офицер хилчдийн хоол хүнс, эд хогшил, хувцас хэрэглэл, орон сууц, уналга, хөсөг, гэрэл түлш зэрэг ахуйн хэрэгцээний зүйлийг бэлтгэн хангаж байсан. Арын албаны мэдэлд агт морь 1000 гаруй, шар ба саалийн үнээ 200 гаруй, ачааны ЗИС-5, хагас ачааны тэрэг /полу тэрэг/, эмнэлгийн машин, МБКВ, М-1, тус бүр нэг, нийт таван машинтай байсан. Отрядын хэрэгцээний бүх хуурай хүнсийг хязгаарын цэргийн Баянтүмэн дэх баазаас шууд хангадаг байсан. Мөн отрядын дэргэд ХҮЯ-ны харьяа мал баазаас махан хэрэглээг хангахдаа хилийн суман заставуудыг амьд малаар хангаж байжээ.

Отрядын төвд сургагч мэргэжилтэн нарт зориулсан 4 айлын 2 дүнзэн байшинд отрядын штаб, хүн малын эмнэлэг цэргийн байр, эд хогшил, хүнсний агуулах зэргийг газар землянка болон эсгий гэр, өөрсдийн хүчээр барьсан шавар барилгад байрлуулан ашиглаж байжээ. Отрядын хэрэгцээний хүнсний ногоо, төмс, байцаа, манжин зэргийг өөрсдийн хүчээр тариалж офицер хилчдийн хүнсний хэрэгцээнд хэрэглэж байсны гадна бүх хэрэгцээний түлшинд аргал түлдэг байв. Дорнод аймгийн Халх гол, Хунт, Маргад зэрэг сумын ард иргэдтэй гэрээ хийж авахын зэрэгцээ хилийн суман, заставууд өөрсдийн бололцоогоор мод, аргал зэргийг бэлтгэж хэрэглэдэг байлаа.

Отрядын байрлал, цаг агаар. Тус отрядын харьяалсан нутаг дэвсгэр нь ерөнхийдөө тал хээрийн бүсэд хамаарагдах ба ой мод, гол мөрөн, булаг шандаар ховор боловч зүүн хэсэгтээ Халх, Нөмрөг, Нарийн гол /Дэгээ/ зэрэг газруудад бага зэрэг ой модтой, бусад газар нутаг нь жижиг уул толгодтой, харин Ламын хайрхан, Халхын цагаан

уул зэрэг томоохон уул нуруу бий. Мөн Азаргын манхан, Сөрийн манханы орчим цөөн тооны жижиг нуур, тойром байдаг. Задгайт, Авдрант зэрэг газарт булаг шандтай. Нийт газар нутаг нь хар шороон хөрстэй, өвс ургамал өндөр ургадаг, газар тариалангийн ажилд тохиромжтой.

Цаг уурын хувьд эрс тэс уур амьсгалтай. өвөл нь цас ихээр унаж, 40 градус хүртэл хүйтрэх ба зундаа халуун, хавар, намрын улиралд хуурай салхитай. Өвс ургамал өндөр учир хээрийн түймэр гарч хүн малд аюул учруулдаг явдал бий. 1940 онд хээрийн түймэр гарч хүн мал осолдож түлэгдсэн ч удаатай.

Ан амьтны хувьд Халх, Нөмрөгийн голын орчим зэрлэг гахай, бор гөрөөстэй, бусад газруудад цагаан зээр, чоно, үнэг, хярс, тарвага элбэгтэй. Ялангуяа чоно маш их элбэг бөгөөд гуринхатсан чоно хог хаясан газар ирж яс идэх төдийгүй ямаан дах нөмөрсөн манаанаас чангаасан, цэргийн байр руу шөнийн цагт орж ирж байсан явдал гарч байжээ. 1946 оны намар Хязгаарын Цэргийн газрын дарга генерал Б.Дорж Баянцагааны отрядын ажилтай танилцаж гурав хоног явахдаа 10 шахам чоно агнасан ба мөн отрядын штабын офицер Лавдан. Даваасүрэн нар мөн онд мал нядалгаа хийсэн газар хавх тавьж 10 гаруй чоно агнаж байсныг үзэхэд чоно үнэхээр элбэг байсных юм.

Татан буугдсан нь. Манай улсын урд хөршид хувьсгал ялж дорно дахинд нэгэнт дайны аюул устсан учир улсын хилийг хүчлэн хамгаалах шаардлагатай болжээ. Ийм учраас Хязгаарын цэргийн цомхотгож зарим отрядыг сумангийн зохион байгуулалтад оруулсан юм. Ингээд Баянцагааны отрядыг тусгай суман болгож, улс төрийн орлогчоор Төмөртотоог томилж байжээ.

Дэлхийн II дайны гал ид дүрэлзэж Германы фашистууд Европын ихэнх улс орныг эзлэн авч улмаар ЗХУ /хуучнаар/ уруу итгэлийг эвдэн довтолж байсан ба дорно зүгт Японы түрэмгийлэгчид Манжуурыг бүрэн эзэлж Хятадын нутгийн нэлээд хэсгийг эзлэн авч манай улсын зүүн ба зүүн өмнөд хилийн шугаманд тулж ирээд эзлэн түрэмгийлэх байлдааны бэлтгэлээ ид бэлтгэж байсан хамгийн хүнд үед эх орноо хамгаалах эрхэм үүргээ нэр төртэй биелүүлж байгаад 11 жилийн дараа **Баянцагааны 23 дугаар отряд** татан буугдсан юм.

Ахмад хилчин Т.Даваасүрэн
З.Чимидрагчаа.